

ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

2021 оны 03 сарын 18 өдөр

Дугаар: 2021/003

Чингис хот

Энэхүү гэрээг Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Хэнтий аймгийн **Батноров** сумын нутаг дэвсгэрт **Ямаат** нэртэй **MV-017189** дугаартай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж буй “**Зэвтдуулга**” ХХК (цаашид “тусгай зөвшөөрөл эзэмшигч” гэх)-тай нутгийн захиргааны байгууллага дараах нөхцөлөөр харилцан тохиролцож, хамтран ажиллахаар байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү гэрээ нь Хэнтий аймгийн Батноров сумын нутагт Ашигт малтмалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу олгосон тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, аймаг, орон нутгийн нийгэм эдийн засгийн хөгжил, хүний хөгжлийг дэмжих, нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэх чиглэлээр нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн тусгай зөвшөөрөл бүхий талбай орших аймаг, сумын байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, нийгэм эдийн засгийн хөгжил, хүний хөгжлийг дэмжих, нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэх чиглэлээр сайн дурын үндсэн дээр дэмжлэг, туслалцаа үзүүлнэ.

Хоёр. Нутгийн захиргааны байгууллагын эрх, үүрэг

2.1. Энэхүү гэрээний хүрээнд нутгийн захиргааны байгууллага дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

2.1.1. Хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийн хүрээнд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн ашигт малтмал хайх, ашиглах, олборлох болон бүтээгдэхүүн тээвэрлэлтийн үйл ажиллагааг тогтвортой хэвийн явуулах нөхцөлөөр дэмжих

2.1.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигчээс гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхийг шаардах, уг гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс учирсан хохирлыг нөхөн төлүүлэх

- 2.1.3. Байгаль орчныг хамгаалах талаар Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүргий биелэлтэд холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хяналт шалгалт хий олборлолтын явцад байгаль орчинд сөрөг нөлөөлөл үүсгэсэн тохиолдолд сөрөг нөлөөллийг арилгуулах арга хэмжээг авч ажиллах, хууль бус үйл ажиллагааг таслаа зогсоох
- 2.1.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч хууль тогтоомж болон энэхүү гэрээгээр хүлээсээ үүргээ биелүүлээгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд уг үүргээ биелүүлтэл, гарсаа зөрчлийг арилгах хүртэл хуулийн хүрээнд холбогдох арга хэмжээг авах
- 2.1.5. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагааг хэвийн явуулахтай холбогдсээ хүсэлт, шаардлагыг хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэж, зохих хариуг өгөх
- 2.1.6. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зарласан ажлын байр болон бараа, ажлыг үйлчилгээ худалдан авахтай холбогдсон мэдээллийг холбогдох байгууллагатай хамтран иргэд, аж ахуйн нэгжүүдэд ил тод, нээлттэй хэлбэрээр хүргэх ажлыг зохис байгуулах
- 2.1.7. Энэхүү гэрээний 3.1.4-т заасан аймгийн Орон нутгийн төсвийн орлогын дансаар шилжүүлсэн мөнгөн дэмжлэгийн **40** хүртэлх хувийг тухайн тусгай зөвшөөрөлтэй талбаа орших **Батноров** сумын Орон нутгийн төсвийн орлогын дансанд тухай бүр шилжүүлэх
- 2.1.8. Орон нутгийн төсвийн орлогын дансанд төвлөрсөн мөнгөн дэмжлэгийг “**Орс нутагт шаардлагатай мэргэжилтэй ажилтан бэлтгэх, хүний нөөцийг бүрдүүлэх**” журмын дагуу зарцуулах ба хэрэгжилтэд тусгайлан хяналт тавьж, иргэд олон нийтийн мэдээлнэ.
- 2.1.9. Орон нутгийн хөгжилд сайн дурын үндсэн дээр үзүүлсэн дэмжлэг, туслалцаа түүний зарцуулалт болон бусад хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний талаар орс нутгийн иргэдэд мэдээлэл хийж саналыг нь авах, тайланг аймгийн “Олборлалыг үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын дэд зөвлөл”-д хүргүүлэх, нийтэд ил тод мэдээлэх ажлыг хариуцан ажиллана.
- 2.1.10. Энэхүү гэрээг хүчин төгөлдөр болмогц ажлын З өдөрт багтаан аймгийн нэгдсэн www.khentii.gov.mn цахим хуудас болон www.iltodgereen.mn эрдэс баялгийн гэрээнд цахим мэдээллийн санд байршуулна.

Гурав. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг.

3.1. Энэхүү гэрээний хүрээнд тусгай зөвшөөрөл эзэмшигч дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.1. Үйл ажиллагаагаа хэвийн, тасралтгүй явуулахад орон нутгийн иргэд, хуулийн этгээдийн зүгээс хууль бусаар саад учруулсан тохиолдолд уг асуудлаар зохих журмын дагуу шат шатны Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хандаж шийдвэрлүүлэх

3.1.2. Нутгийн захиргааны байгууллагаас гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхийг шаардах

3.1.3. Тусгай зөвшөөрөл бүхий талбайд Монгол улсын хууль, тогтоомж эрх бүхий байгууллагаас гаргасан тогтоол, шийдвэрийг хүндэтгэн биелүүлж, тавьсан шаардлагыг хэрэгжүүлэн ажиллах

3.1.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд сайн дурын үндсэн дээр дэмжлэг болгож 2021 оноос эхлэн 2024 он дуустаг жил бүр **20000000** /хорин сая/ төгрөгийг Хэнтий аймгийн Орон нутгийн төсвийн Бусад орлогын дансанд шилжүүлнэ.

Банкны нэр: Төрийн сан банк

Дансны нэр: Хэ. Бусад нэр заагдаагүй орлого

Дансны дугаар: 100180000955

3.1.5. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэхүү гэрээний 3.1.4-т заасан сайн дурын үндсэн дээр үзүүлэх тухайн оныхоо санхүүгийн дэмжлэгийг 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор бүрэн шилжүүлж дуусгасан байна.

3.1.6. Орон нутгийн төсвийн дансанд төвлөрүүлсэн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ, түүний үр дүнгийн талаар мэдээлэл, тайлан авах

3.1.7. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь компанийн үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй мэдээ, мэдээллийг аймгийн нэгдсэн цахим www.khentii.gov.mn хаягны "хариуцлагатай уул уурхай" хуудсанд ил тод нээлттэй байршуулах

3.1.8. Компанийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл болон хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийн талаар орон нутгийн иргэдэд танилцуулах ажлыг нутгийн захиргааны байгууллагатай хамтран жил бүрийн 4, 10 дугаар саруудад үр дүнтэй зохион байгуулж, иргэдийн саналыг авч үйл ажиллагаанд тусгаж, хэрэгжүүлэх ажиллана.

3.1.9. Гамшгийн үед тухайн орон нутагт техник, тоног төхөөрөмж, ажиллах хүч болон бусад материаллаг туслалцаа үзүүлэх

3.1.10. Нутгийн захиргааны байгууллага, холбогдох төрийн байгууллагаас зохи байгуулж буй салбарын үйл ажиллагаатай холбогдох сургалт, зөвлөгөөн, олон нийти арга хэмжээнд компанийн оролцоог хангаж, төлөөллөө идэвхитэй хамруулах

3.2. Ажиллагсдын амьдрах, хөдөлмөрлөх орчин нөхцөл, нийгмийн хамгааллы талаар:

3.2.1. Ажилтан ажиллагсдын амьдрах, хөдөлмөрлөх орчин нөхцлийг Монгол улс холбогдох стандартад нийцүүлнэ.

3.2.2. Ажилтан, ажиллагсдын цалин, хөдөлмөрийн хөлсний хэмжээг Монгол улс Засгийн газраас баталсан нийгмийн зөвшилцлийн гурван талт хэлэлцээрээр Эрч хүч, геологи, уул уурхайн салбарт тогтоосон цалингийн жишгээс доошгүйгээр тогтоо

3.2.3. Ажилтан, ажиллагсдын амьдрах байр, чөлөөт цагаа өнгөрүүлэх орчинг эру ахуйн стандартын дагуу тохижуулж, ажилтан, ажиллагсдыг эрүүл мэндийн урьдчиг сэргийлэх иж бүрэн үзлэг, оношлогоонд тогтмол хамруулна.

3.2.4. Ажлын байран дахь осол, мэргэжлээс шалтгаалсан өвчлөл, бусад эрсдэл урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, ХАБЭА-н хуваарын сургалтыг улирал тут тогтмол зохион байгуулж, үр дүнгийн талаарх тайлан мэдээллийг аймги Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлд хүргүүлнэ.

3.3. Байгаль орчныг хамгаалах чиглэлээр:

3.3.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хайгуул, ашиглалт, бусад үйл ажиллагааны явь тусгай зөвшөөрөлтэй талбайд орших булаг шанд бүхий газрыг хөндөхгүй, ургамал, амьтан, байгаль экологийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүй ба түүх, соёлын дурсга зүйлийг хамгаалж ажиллана.

3.3.2. Үйл ажиллагааны явцад байгаль орчныг хамгаалах, байгаль орчинд сөи нөлөөлөл үүсгэхээс урьдчилан сэргийлэх ажлыг хариуцлагатай, үр дүнтэй зохи байгуулж, сөрөг нөлөөлөл бий болж, байгаль орчны бохирдол үүссэн тохиолдс нөхөн сэргээх ажлыг хууль тогтоомж, стандартын дагуу гүйцэтгэж, мэргэжлийн байгууллагад хүлээлгэн өгнө.

3.3.3. Тухайн жилийн Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөнд байгаа орчныг хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах болон дүйцүүлэн хамгаалах аг

хэмжээг тусгахдаа нутгийн захиргааны байгууллага, мэргэжлийн байгууллагын саналыг авах ба төлөвлөгөөний биелэлтийг бүрэн хангаж, хуулийн хугацаанд дүгнүүлж ажиллана.

3.3.4. Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгаж батлуулсан байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний нийт зардлын 50 хүртэлх хувийг холбогдох хуульд заасны дагуу барьцаа болгон тухайн сумын Байгаль орчны нөхөн сэргээлтийн дансанд үйл ажиллагаа эхлэхээс өмнө байршуулна.

3.3.5. Хоёр жил тутамд байгаль орчны аудит хийлгэнэ.

3.3.6. Үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах усны дүгнэлтийг жил бүр холбогдох мэргэжлийн байгууллагаар гаргуулж, ус ашигласны төлбөр, АМНАТ, газрын төлбөр, хог хаягдлын хураамж, үл хөдлөх хөрөнгийн албан татвар, ХХОАТ зэргийг хуулийн хугацаанд төлөх, тайлагнах үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллана.

3.3.7. Ашигт малтмал олборлолт, ашиглалтын үйл ажиллагаанд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн ус хамгийн багаар хэрэглэгддэг тэргүүний дэвшилтэт, байгальд ээлтэй технологи нэвтрүүлж ажиллах ба үйлдвэрлэлд ашигласан саарал усыг дахин ашиглана.

3.4. Зам тээвэр дэд бүтцийн чиглэлээр:

3.4.1. Бүтээгдэхүүн тээвэрлэх автозамын чиглэл маршрутыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу батлуулна.

3.4.2. Маршрутын дагуу бүтээгдэхүүн тээвэрлэх хүнд даацын авто машины тоо, даацын хэмжээ, бусад мэдээллийг холбогдох байгууллагад бүртгүүлж автозам, гүүрийг ашиглах зөвшөөрөл авна.

3.4.3. Автомэдрэлийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага MNS 4598:2011 стандартын дагуу автомэдрэлийн хэрэгслийн бүх жингийн зөвшөөрөгдөх дээд хэмжээг 44 тонноос хэтрүүлэхгүйгээр бүтээгдэхүүн тээвэрлэнэ.

3.4.4. Бүтээгдэхүүн тээвэрлэхдээ хөрсний доройтол, салаа зам, тоосжилт үүсгэхгүй байна. Мөн бүтээгдэхүүн тээвэрлэлтийн автозамын засвар арчлалтыг хийхэд шаардлагатай хөрөнгийг тухайн жилийн үйл ажиллагааны төсөвтөө тусган, шаардлагатай техник хэрэгслийг гаргаж, жилд хоёроос доошгүй удаа засвар арчлалтыг хийж ажиллана.

3.4.5. Автозамын засвар арчлалтын ажлыг нутгийн захиргааны байгууллагын саналыг авч хамтран төлөвлөнө.

3.5. Ажлын байр нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлт, хүний хөгжлийг дэмжих чиглэлээр:

3.5.1. Орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажлын байраар хангаж ажиллана.

3.5.2. "Орон нутагт шаардлагатай мэргэжилтэй ажилтан бэлтгэх, хүний нөөцийг бүрдүүлэх" журмын дагуу нутгийн захиргааны байгууллагатай хамтарч ажиллана.

3.5.3. Салбарын мэргэжлээр суралцаж буй оюутнуудыг дадлага хийх нөхцөл боломжоор хангана.

3.5.4. Уурхайн нийт ажилтан, ажиллагсдын 80-аас доошгүй хувийг аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан нутгийн захиргааны байгууллагаар дамжуулан холбогдох журмын дагуу нээлттэй сонгон шалгаруулж авна.

3.5.5. Уурхайн ажилтан, ажиллагсдыг сонгон шалгаруулж авахдаа Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан нутгийн захиргааны байгууллагад бүртгэлтэй тухайн сумын болон Хэнтий аймгийн иргэдэд давуу эрх олгож тэргүүн ээлжинд сонгон авна.

3.6. "Нийгмийн хариуцлага"-ыг нэмэгдүүлэх бусад чиглэлээр:

3.6.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн жилийн үйл ажиллагаанд шаардагдах хүнс, бараа бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээг худалдан авах жагсаалтыг гаргаж, тухайн оны эхний улиралд багтаан Аймаг, сумын Засаг даргын Тамгын газарт хүргүүлнэ.

3.6.2. Худалдан авах ажлыг ил тод, нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг шударга хийж, бараа бүтээгдэхүүн худалдан авалт болон бусад туслан гүйцэтгэх ажил, үйлчилгээний 50-аас доошгүй хувийг Хэнтий аймгийн татварын хэлтэст бүртгэлтэй, аймгийн болон тухайн сумын жижиг, дунд үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэгч иргэд, нөхөрлөл, хоршоо, аж ахуйн нэгжүүдэд давуу эрх олгон гүйцэтгүүлнэ.

3.6.3. Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл, холбогдох тайлан мэдээг хагас болон бүтэн жилээр гаргаж аймаг, сумын Засаг даргад жил бүрийн 6 болон 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ.

Дөрөв. Хамтын ажиллагааны хороо

- 4.1. Гэрээний хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий Хамтын ажиллагааны хороо (цаашид “Хороо” гэх)-г төрийн байгууллага, тусгай зөвшөөрөл эзэмшигч болон тухайн орон нутгийн иргэдийн төлөөллийг оролцуулан байгуулж ажиллуулна. Иргэдийн төлөөллийг тухайн багийн иргэдийн Нийтийн хурлаас нэр дэвшүүлнэ.
- 4.2. Хорооны ажиллах журмыг аймгийн Засаг дарга батлах бөгөөд бүрэлдэхүүнийг сумын Засаг дарга нэр дэвшүүлж, аймгийн Засаг дарга томилж, чөлөөлнө.
- 4.3. Хороо нь 9 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд талуудын оролцоог тэгш хангасан байна.

Тав. Тайлагнах, дүгнэх

- 5.1. Хамтын ажиллагааны хороо нь гэрээний биелэлтэд жил бүр хяналт тавьж, тайланг тухайн оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор аймаг, сумын Засаг даргын Тамгын газарт хүргүүлнэ.
- 5.2. Талууд Хамтын ажиллагааны хорооны тайлантай танилцан, цаашид авах арга хэмжээний талаарх саналаа дэвшүүлэн, тайланг дараа оны 02 дугаар сард багтаан аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн хуралд хүргүүлнэ.
- 5.3. Талууд гэрээний биелэлтийг дүгнэж, хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнгийн талаар нутгийн захиргааны байгууллага, иргэд, олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлнэ.

Зургаа. Хариуцлага, маргаан шийдвэрлэх

- 6.1. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн, гэрээний хэрэгжилтийг хангалтгүй биелүүлсэн тохиолдолд холбогдох хуулийн дагуу зохих хариуцлага хүлээх бөгөөд энэ нь хууль тогтоомжоор хүлээсэн бусад үүргээс татгалзах үндэслэл болохгүй.
- 6.2. Талуудын хооронд гэрээтэй холбоотой үл ойлголцол, маргаан үүссэн тохиолдолд хэвийн ажиллагааг хангах нөхцөлөөр харилцан зөвшилцэж шийдвэрлэх ба зөвшилцэлд эс хүрвэл холбогдох хуулийн дагуу шийдвэрлэнэ.

Долоо. Гэрээний хугацаа, гэрээг цуцлах

- 7.1. Энэхүү гэрээг 4 жилийн хугацаатай байгуулав.

7.2. Гэрээний аль нэг тал гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхээс татгалзсан, удаа дараа ноцтой зөрчсөн тохиолдолд нөгөө талын санаачлагаар гэрээг цуцалж болно. Гэрээг зөвхөн хууль болон энэ гэрээнд заасан үндэслэлээр цуцална.

7.3. Гэрээний хугацаа дууссанаар гэрээ дуусгавар болно.

7.4. Талуудын аль нэг нь байгалийн болон гэнэтийн давагдашгүй нөхцөл байдлын улмаас гэрээнд заасан үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээгээр хүлээсэн үүргээс харилцан чөлөөлөгднө.

Найм. Бусад


8.1. Хамтын ажиллагааны энэхүү гэрээ нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн бусад туслан гүйцэтгэгч нарт нэгэн адил үйлчилнэ.

8.2. Талууд гэрээний 5.1-т заасан тайланг харгалзан гэрээг дүгнэж, шаардлагатай тохиолдолд аль нэг талын санаачлагаар харилцан тохиролцож гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Нэмэлт, өөрчлөлт нь гэрээний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд түүний салшгүй хэсэг байна.

8.3. Гэрээг Монгол хэлээр **3 хувь** үйлдэж, талууд тус бүр 1 хувийг хадгална.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

НУТГИЙН ЗАХИРГААНЫ
БАЙГУУЛЛАГЫГ ТӨЛӨӨЛЖ:



АЖ АХУЙН НЭГЖИЙГ ТӨЛӨӨЛЖ:



Н.АМАР

Хаяг: